



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 53

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, түүний биелэлтийн явцыг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД

ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2015 онд хүрэх түвшин, үр дүн	2015 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр /тэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
Зорилт 16. Эрүүл мэндийн салбарт орчин үеийн техник, технологийг ашиглахыг дэмжинэ.						
16.1	ҮХЦБ-ын Стратегийн зорилт 2, ЗГҮАХХАХТ-ний 167.2 дахь заалт	Импортын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах шинэчлэлийг хийх	Олон улсын итгэмжлэл авсан байгууллагын тоо	1	0.1 Улсын төсөв	ЭМЯ
16.2	ЗГҮАХХАХТ-ний 183.2 дахь заалт	Орчин үеийн эмийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, уламжлалт эм, тангийн үйлдвэрлэлийг өргөтгөх	Уламжлалт эмийн бүртгэлд хамрагдах хувь	25 хүртлэх хувь	0.04 Улсын төсөв	ЭМЯ
16.3	ЗГҮАХХАХТ-ний 164.1 дэх заалт	Мэс заслын тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх өндөр өртөг бүхий мэс заслын хэрэгсэл, протезийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх	Эрх зүйн орчин бүрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	15.0 Эрүүл мэндийн даатгалын сан	ЭМЯ
16.4	ЗГҮАХХАХТ-ний 165.1 дэх заалт	Эх орондоо чанартай оношилгоо эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлж, оношилгоо эмчилгээний чанарын стандартыг шинэчлэх	Шинээр боловсруулах стандарт, удирдамжийн тоо	10	0.01 Улсын төсөв	ЭМЯ

16.5	Нийгмийн халамжийн тухай хуулийн 21.1.2 дахь заалт, 21.3 дахь хэсэг	Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо	35 мянга гаруй хүн	0.4 Улсын төсөв	ЭМЯ
16.6	ЗГҮАХХАХТ-ний 185.2 дахь заалт	Хүн амын эрүүл мэндэд хотжилтын нөлөөлөх нөлөөг судлан “Хотжилт ба эрүүл мэнд” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Боловсруулж, хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо,	1	0.35 Улсын төсөв	ЭМЯ